

09 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын 10-нд тэмдэглэн өнгөрүүлдэг тогтсон уламжлалын дагуу аймгийн салбар комисс энэ өдөр хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэж Ерөнхий сайд асан Цэнгэлтийн Жигжиджавын хөшөөнд цэцэг өргөж хэлмэгдэгсдийн хойдын буянд зориулж ном хуруулсан ба ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад "Хэлмэгдлийн хор уршиг, сургамж" сэдвээр хичээл орж, мэдээлэл өгсөн ба сурагчдын хамт телевизийн нэвтрүүлэгт оролцох зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Ж.Бат-Эрдэнэ Сүхбаатар аймагт ажиллаж, Баруун-Урт-Дарьганга чиглэлийн 60 км хатуу хучилттай замын ажлын талаар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатартай санал солилцон, нэн тэргүүнд зураг төсөв болон ТЭЗҮ-ийг боловсруулж бэлэн болгохыг чиглэл болголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч энэ сарын 12-ны өдөр тус аймагт ажиллаж, Алдарт эхийн 1-р зэргийн одонг 10 эхэд, 2-р зэргийн одонг 204 эхэд олгосон бөгөөд одонтой ээжүүдэд тусгайлан баяр хүргэж хүндэтгэл үзүүллээ. Түүнчлэн Баруун-Урт сумаас 6 км зайд орших Сайншанд-Баруун-Урт чиглэлийн 317 км төмөр замын төгсгөлийн цэг буюу төмөр замын өртөө болох газар, Баруун-Урт сумын ЕБС-ийн 4-р сургууль зэрэг газруудад ажилласаны зэрэгцээ аймгийн иргэдтэй уулзалт хийж, тэдний санал хүсэлтийг сонслоо.

УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нар 9 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд бүх суманд "Талархлын уулзалт" хийж, 13 сумын 3000 гаруй иргэнтэй уулзаж УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцсэн асуудлууд, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Сүхбаатар аймагт хэрэгжих хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын талаар танилцуулан, орон нутгийн иргэд сонгогчдынхоо санал хүсэлтийг сонсож ажилласны зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон медалиар шагнагдсан хүмүүсийн шагналыг гардуулан өгсөн байна.

Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатараар ахлуулсан ажлын хэсэг 09 дүгээр сарын 27-ны өдөр тус аймагт ажиллаж, салбарын байгууллагын үйл ажиллагаатай танилцсан ба Шадар сайд Я.Содбаатар аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжилзүйн хэлтсийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, ОБГ-т Европ стандартын тусгай тоноглол бүхий автомашин, Түмэнцогт сумын гал унтраах бүлэгт фургон маркийн автомашин тус тус олгох, СХЗХ-ийн автомашины асуудлыг тухайн онд багтаан шийдвэрлэж өгөхөөр болсон байна.

Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг аймгийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлууд, бодлого шийдвэрийн талаар танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг сонссон ба орон нутагт тулгамдаж буй зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэлээ. Тухайлбал: Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дурангийн хагалгааны тоног төхөөрөмжөөр хангах, 4-р багийн иргэн Баярбаатарын залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр тавьсан асуудлын дагуу тухайн иргэнээс энэ чиглэлийн төслийг холбогдох яаманд ирүүлэх чиглэл өгч, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхээр боллоо.

Сүхбаатар аймаг 2020 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарласан ба энэ хүрээнд аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар Монголын Залуучуудын Холбооны Сүхбаатар аймаг дахь салбарын үйл ажиллагааг дэмжиж, 7-р багийн нутаг дэвсгэрт байдаг Жаргалан хотхонд 120 мкв байрны асуудлыг шийдвэрлэж өглөө.

Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн мэргэжилтнүүд хамтран Чехийн элчин сайдын яамнаас зарласан тэтгэлэгт хөтөлбөрт болох "Алслагдсан сумдтай холбогдох онлайн

мэдээллийн тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл болон “Иргэдийн оролцоо” –г дээшлүүлэх чиглэлээр 65 сая төгрөгийн төслийн санал боловсруулж Канад санд хүргүүлээд байна.

Төрийн албаны салбар зөвлөл: Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа барилга хот байгууллагын газар зэрэг 5 байгууллагын 24 ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулсан. Уг шалгалтанд 12 иргэн sukhbaatar@csc.gov.mn хаягаар материалаа ирүүлсэн бөгөөд 2 иргэн албан тушаалын тодорхойлолтод тусгасан тусгай шаардлага хангаагүй шалтгаанаар хасагдаж, 10 иргэн тусгай шалгалтанд хамрагдсанаас хамгийн өндөр оноотой 5 иргэнийг ажлын байранд томилуулахаар тухайн байгууллагад санал болгон хүргүүллээ.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн улсын зөвлөгөөнд аймгийн төрийн захиргааны 2 албан хаагч, төрийн үйлчилгээний 2 албан хаагч оролцсон бөгөөд агентлаг, албадын удирдлага, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид онлайн байдлаар тус зөвлөгөөнд хамрагдсан.

Удирдлагын академийн богино хугацааны чиглүүлэх онлайн сургалтад төрийн захиргааны байгууллагад шинээр томилогдон ажиллаж байгаа 9 албан хаагч хамрагдаж байна.

Онгон, Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Төрийн албаны нөөц бүрдүүлэх зорилготой Ерөнхий шалгалтын бүртгэл улсын хэмжээнд 9 дүгээр сарын 14-ний өдөр эхэлсэн бөгөөд орон нутгийн иргэдэд зөвлөгөө мэдээллийг хүргэж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Одоогоор аймгийн хэмжээнд 1 дүгээр сард 167 иргэн бүртгэгдсэн бол шинээр 24 иргэн бүртгүүлээд байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2020 оны 9 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 33,981,0 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 5,376,4 сая төгрөгийн орлого орж нийт 35,634,1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 9 сарын байдлаар улсын төсөвт 2085.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 1590.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 76,3 хувиар, Орон нутгийн төсөвт 7177,3 /Сумдууд орсон/ сая төгрөг төвлөрүүлэхээс 7044,8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 98,2 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 4,312,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 42,249,8 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

ОНХС-ийн орлогын шилжүүлэгийн 12387,1 сая төгрөг/ жилийн дүнгээр/ үүнээс эхний 9 сарын байдлаар 5929,5 сая төгрөгийн орлогын шилжүүлэг шилжиж ирсэн. Үүнээс сумдын орон нутгийн хөгжлийн санд итгэлцүүрийн дагуу 2062,7 сая.төгрөг хуваарилсан. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 1688,9 сая.төгрөг, Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 802,3 сая.төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тооцооллыг боловсруулан, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газар: 2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар нийт 94 нэр төрлийн 23699,2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ төлөвлөгдсөнөөс: 09 дүгээр сард нийт 4,32,100,000 төгрөгийн 3 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг цахимаар зарласан бөгөөд үр дүн гарсан 2 тендер , хүлээн авах хугацаа дуусаагүй 1 тендер байна. Мөн тухайн сард 2 нэр төрлийн тендерийн нээлт хийж,

гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид холбогдох зөвлөмжийг /нийт 124,894,816 төгрөг/ хүргүүлсэн байна.

Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит 7 байгууллагаас ирсэн санал хүсэлтийг тухай бүр хариуг шийдвэрлэсэн.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Энэ сард албаны даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Хөгжимт жүжгийн театр, Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн болон дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд 6 салбар актаар 11092.9 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож ажиллалаа.

Статистикийн хэлтэс: Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны /Малын ашиг шим болон газар тариалангийн судалгаа/ эхний 2 улирлын мэдээллийг сонгогдсон 8 сумын 8 багийн 160 өрхөөр бөглүүлэн татан авч, хянаж шалгах ажил хийж, програмд оруулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлээд байна.

Үндэсний статистикийн хорооны ЭЗСГ-ын статистикч Мандахзориг, хэлтсийн дарга Т.Эрдэнэбат нар Асгат, Эрдэнэцагаан, Онгон, Мөнххаан сумдад ажиллалаа.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 9-р сарын мэдээллийг 9 сумын 11 нэгжээс 102 өрхөөс цуглуулан ажиллаж байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: “Боловсролын салбарын хүүхэд хамгааллын бодлого” сургалт зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнууд, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, эмч нийт 86 хүн хамрагдл. Сургалтыг Хүүхэд хамгаалах “Үжин төв”-ийг үүсгэн байгуулагч, үндэсний сургагч багш Ундраа удирдан зохион байгуулсан.

Хүүхдийг гэмт хэргээс хамгаалах “Сүүдэр бүү тусга” аянд боловсролын салбар нэгдсэн.

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд багш нарын танхимын болон цахим сургалт зохион байгуулагдсан.

Халзан сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгыг хүлээн авах улсын комисс ажиллаж, сургуулийн дотуур байрын засварын ажлыг хүлээн авсан.

Соёл урлагийн байгууллагууд “Соёлын цаг” нээлттэй хаалганы өдрийг Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийн хүрээнд “Номын баяр”-ын арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын удирдамжийн дагуу зохион байгуулж 13 сумын боловсрол, соёлын байгууллагуудын номын санч нар хамрагдан, номын санч нарт сургалт зохион байгуулагдсан.

МҮОНТ, Бидний цөөхөн Монголчууд төслийн баг Зүүн Монгол Дорнын гоёл дуу бүжгийн чуулбар, Дарьганга дарханы урлалаар баримтат кино зураг авалт хийсэн ба Жаахан шарга ХЖТ, Угсаатны зүйн музейн уран бүтээлчид оролцсон.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, аймгийн Засаг Даргын 2019 оны А/268

дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын асрамж, халамж хамгаалал, нөхөн сэргээх төвүүдийн нэгдсэн холбооны тэргүүн Д.Ундраатай хамтран зохион байгууллаа. Сургалтад байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн дарга нарыг хамрууллаа.

ХЗДХЯам Японы ядуурлыг бууруулах сан ADB-тэй хамтраад зохион байгуулж буй “ХБИргэдийн амьдралын үйл явц ямар түвшинд байгааг судлах” судалгааг IRIM-Хараат бус судалгааны хүрээлэн гүйцэж 9 сарын 7-9-ны өдрүүдэд ажиллалаа. Уг судалгаанд Сүхбаатар аймгийн хэмжээнд Асгат сумын хамтарсан багийн 4 гишүүн, 9 төрийн албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 30 иргэн нийт зорилтот 43 иргэн хамрагдаж, нэмж асран хамгаалагч 10 иргэн бүлгийн зөвлөгөө авч нийт 53 иргэнийг хамрууллаа.

Гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн зөрчлийг илрүүлэх, иргэдийг сонсох, Корона вируст Ковид-19 халдварт цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэрээр айлчлах” 14 хоногийн аян 12 суманд зохион байгуулан ажиллаж байна.

Шинээр кейс нээж үйлчлүүлэгч нарт холбогдох үйлчилгээг үзүүлж, харъяаллын дагуу хамтарсан багт шилжүүлэн хяналтадаа авч ажиллаж байна

Байгууллагын даргын 2020 оны 9 сарын 23-ны өдрийн А/30 тушаалаар гамшиг онцгой байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгааллын талаар хууль тогтоомж төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх хамтарсан багт мэдээлэл арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг 3 суманд зохион байгуулж ажиллалаа.

“Гэр бүлийн боловсрол” олгох мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг “Сэтгэл зүйч зөвлөж байна” пэйж хуудас ажиллуулж байна. Гэр бүлийн зөрчил үйлдэж Аймгийн цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж 31 иргэн хамрагдлаа.

Улаанбаатар хотод 9 сарын 14 - 9 сарын 18 өдрүүдэд ОУХЭЗБ-ын зохион байгуулж байгаа “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ” сэдэвт Сургагч багш бэлтгэх сургалтад 1 мэргэжилтэн хамрагдлаа.

Зэвсэгт хүчний 338-р ангид сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан. Гэр бүлийн харилцаа, Гэр бүлийн үнэ цэнэ, Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, сургалт, “Эх оронч залуу” лекцыг зохион байгуулсан. Нийт 57 залуу хамрагдсан.

“Хайрын түүх” телевизийн нэвтрүүлэг : Аймаг орон нутагтаа ажил амьдрал ахуйгаараа амжилт гаргаж бусдад үлгэр жишээ болж байгаа залуу манлайлагч 3 гэр бүлийг оролцуулан орон нутгийн телевизээр олон нийтэд цувралаар хүргэж байна. Үүнд: Б.Наранцогт, Б.Мөнхзориг, Б.Алтансүх нарын гэр бүл оролцсон.

Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлийн эерэг харилцаа бий болгох, амьдрах ухаанд сургах, номоор дамжуулж тэдэнд зөв хандлагыг бий болгох, өсвөр үе, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих зорилгоор “Хос Нот” гэр бүлийн харилцаа сэдэвт өглөөний “виб” уулзалт, “Хүн өөрийгөө бүтээдэг” ЕБС-ын ахлах ангийн сурагчдтай хийх уулзалт, Номын үзэсгэлэн худалдаа, “Нар хүнээс манддаг” Залуучуудтай уулзах нээлттэй уулзалтыг Сүхбаатар аймгийн залуучуудын холбоо, “Судартан Бэхи” ТББ, “Positive womens” клубтэй хамтран зохион байгуулсан.

9 сарын байдлаар ХТУ-108-д 2 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна. Биеэр болон утсаар хандсан- 3. Хүүхэд тус бүрт хувийн хэрэг нээж шаардлагатай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Хувийн хэрэг нээн ажиллаж буй 2 тохиолдолд гэр бүлийн болон эрсдэлт нөхцөл байдлын үнэлгээг хийж ажилласан.

9 дүгээр сарын 02-ны өдрөөс “Хүүхдийн эрхийн мэргэжилтэн зөвлөж байна” хүүхэдтэй холбоотой бүхий л асуудлаар холбогдож зөвлөгөө мэдээлэл авах боломжтой цахим хуудсыг нээсэн. Тус хуудсаараа дамжуулан хүүхэдтэй хэрхэн харилцах, ярилцах шаардлагатай үедээ хаана хэнд холбогдох гэх мэт шаардлагатай зүйлсийг түгээж байна.

2019 онд нээгдсэн хувийн хэргүүдийн бүрдлийг шалган сумдын хамтарсан багуудад аргагүйн зөвлөгөөг өгч ажилласан. Мөн туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй өрхүүдийн хүүхдийн судалгааг авч эрсдлийн программд шивж оруулахад бэлтгэж байна.

Угсаатны зүйн музей: Түүх соёлын хосгүй үнэт зүйлийн судалгааг Соёлын өвийн үндэсний төвд явууллаа.

Эх хэлний өдрийг тохиолдуулан ЕБС-ийн багш сурагчидтай хамтран өөрийн байгууллагын сийлбэрийн танхимаар хичээл бэлтгэсэн.

"Соёлын цаг" нээлттэй арга хэмжээний хүрээнд "Мөнгөн аяга" үзэсгэлэн, шоон тоглоом, Батхолбоо тоглоом зэрэг уламжлалт тоглоомоор хэрхэн тоглох талаар сурагчдийн дунд боловсролын ажил зохион байгуулсан.

Халзан сумын Дөхөм баригадын нутагт "Зүүн монгол дорнын гоёл" дуулалт жүжгийн клипны зураг авалт хийгдлээ. Тус зураг авалтанд гэр болон гэр доторх үзмэрийг дэгэлж оролцсон.

Хөгжимт жүжгийн театр: "Зүүн Монгол дорнын гоёл" дуу, хөгжим, бүжгийн чуулбарыг дүрсжүүлэх ажлыг Халзан сумын Дөхөмийн бригадэд 9 сарын 14 – 16 – ны хооронд "Бидний цөөхөн Монголчууд" төслийн баг болон Монголын үндэсний телевизтэй хамтран хийсэн.

"Соёлын цаг" хөтөлбөрийн хүрээнд "Найрсан Баруун Урт- 2" арга хэмжээг хоёрдох удаагаа Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд "Жаахан шарга" театр нь уран бүтээлийн дээжсээс хүргэж, иргэдээс үзэгчдийн судалгаа авч, Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан шинэ номын үзэсгэлэн, Угсаатны зүйн музей ховор үзмэрүүдээ үзэгч олондоо танилцууллаа.

Сүхбаатар аймгийн Залуучуудын холбоотой хамтран лектор П. Буяндэлгэрийн "Нар хүнээс манддаг" лекцийг зохион байгуулсан.

Нийтийн номын сан: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлигийн дагуу "Нээлттэй хаалганы өдөр"-ийг соёлын байгууллагуудын "Соёлын цаг" хөтөлбөрийн хүрээнд Жаахан шарга" театр, Угсаатны зүйн музейтэй хамтран Д. Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Арга хэмжээнд шинэ номын болон хүүхдийн номын 50, Монголын нууц товчооны дээжсээс 20 гаруй ном, үнэт ховор номын үзэсгэлэн 6, нутгийн зохиолчдын худалдаа 25 нийт 100 гаруй ном, Монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэн зэргийг гаргаж, уншигч, хэрэглэгчдээс судалгаа авсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баяр" тэмдэглэн өнгөрүүлэх 158 дугаар зарлигийн дагуу "Номын баяр-2020" арга хэмжээ "Хязгаар үгүй-НОМ- сэтгэлгээний эрх чөлөө" уриан дор зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 1000 гаруй хүн оролцсон. Арга хэмжээнд сум, сургуулийн нийт 29 номын санчид, зохиолч, яруу найрагчид, ЕБС-ийн тэргүүний уншигч хамт олон, номын клубын сурагчид, ном борлуулагч газрууд, ахмад номын санчид, идэвхтэн уншигч нар хамрагдсан. Мөн энэ үеэр номын санчдын нэгдсэн сургалт зохион байгуулж, СУИС-ийн харьяа Соёлын боловсролын дээд сургуулийн багш Т. Хайдав, Хүүхдийн төв номын сангийн хэлтсийн дарга Г. Дарьсүрэн. Арга зүйч Л. Батболор нар "Цахим номын сангийн үйлчилгээ", "ЕБС-ийн номын сангийн үйл ажиллагаа ба орчин үе", "Хүүхдийн ном унших дадлыг хэвшүүлэх нь", "Хүүхдийн Төв номын сангийн соёл танин мэдэхүйн ажлууд", "Хүүхдийн уншлаганд эцэг эхийн оролцоо" Monbiblo цахим үйлчилгээг идэвхижүүлэх нь зэрэг сэдвээр сургалт явууллаа.

"Орчин үеийн номын сангийн үйлчилгээ ба уншигчийн хэрэгцээ" хэлэлцүүлэг зохион байгуулж, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ц. Оюундэлгэр, ахмад номын санч М. Дэнсмаа, идэвхитэн уншигч Мөнхжаргал нар уригдан оролцсоноос гадна сум, сургуулийн бүх номын санч нар хамрагдсан. Номын өдөрлөг арга хэмжээний үеэр шинэ номын хямдралтай худалдаа болон уншигчийн гар дээрх номын худалдаа, нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн худалдаа, үнэт, ховор номын үзэсгэлэн, ном сурах бичгийн солилцоо, ном хандивын аян, сум, сургуулийн номын сангуудын үйл ажиллагааны танилцуулга, богино өгүүллэгийн уралдаан зэрэг арга хэмжээ зохион байгуулагдсан.

"Богино өгүүллэгийн уралдаан" 2 үе шаттайгаар зохион явуулж, 1-р шатны уралдааныг цахимаар явуулахад нийт 20 гаруй хүн бичлэгээ ирүүлж, 2-р шатанд ЕБС болон насанд хүрэгчдээс нийт 9 хүн өрсөлдөж шилдэгүүдийг шалгаруулсан. "Номын баяр-2020" арга хэмжээний хүрээнд "Шилдэг ном", "Шилдэг уншигч"-ийг тодруулсан.

“Монгол ардын баатарлаг тууль” номыг үнэ төлбөргүй тараахтай холбогдуулж, бүх сумын соёлын төвийн номын сангуудад тус бүр 5 ш нийт 65 ш номыг болон Номын баярыг угтаж зарласан “Ном хандивын аян”-д цугларсан номуудыг хүлээлгэн өгч, шилдэг ном хандивлагч байгууллага, иргэнийг шалгаруулав.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Энэ сарын 18-ны өдөр “Талын бөмбөг” Сүхбаатар аймгийн сурагчдын волейболын анхдугаар лигийн тэмцээний шигшээ тоглолтууд БТСГ-ын “Б” зааланд зохион байгуулагдан, 108 тамирчид оролцож “12 star ball” баг тэргүүн байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

Мөн спортын төв зааланд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдан 3-р сургуулийн Тасхүү дасгалжуулагчтай Төрболд ахлагчтай баг тэргүүн байр эзэлсэн.

Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газартай хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг волейболын тэмцээнд 1-р 10 жилийн сургуулийн Б.Гантулга ахлагчтай эрэгтэй баг тамирчид тэргүүн байр, Б.Оюунсүвд ахлагчтай эмэгтэй баг тамирчид дэд байр эзэлж багийн дүнгээр Шилжин явах цом хүртлээ.

“BEST” төвийн нэрэмжит 2020 оны аймгийн шатрын аварга шалгаруулах түргэн болон түргэвчилсэн тоглолтын анхдугаар тэмцээн амжилттай зохион байгуулагдсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг 21 аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн хөл бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцон 5-р байр эзэлсэн.

Монголын дугуйн холбооны ерөнхийлөгчийн нэрэмжит засмал замын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээнд багийн дүнгээр 1-р байр эзэлсэн.

Шатарчдын түргэвчилсэн тоглолтын улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 3 мөнгөн медаль авсан үзүүлэлтээр багийн дүнгээрээ 4-р байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Цагаан бэрс-2020” өсвөрийн шатарчдын түргэн болон түргэвчилсэн тоглолтын улсын аварга шалгаруулах XIV тэмцээнд баг тамирчид амжилттай оролцсон.

Ахмадын улсын аварга шалгаруулах софт волейболын тэмцээнд баг тамирчид оролцсон.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 09-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 704 иргэнээс эмэгтэй 350, бүртгэлтэй ажилгүй иргэн 525 иргэнээс, эмэгтэй 250 иргэн байна. 592 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 541 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 301 иргэн буюу 55,6% нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 412 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуй нэгж байгууллагын 2 гадаад/хятад/ ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.

ХХҮГазрын даргын батлагдсан удирдамжийн дагуу Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад шинээр бий болсон ажлын байрны мэдээллийг маягтаар бүртгэн, ХЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд 10 ажил олгогчийн 302 ажлын байрыг мэдээлээд байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас улсын хэмжээнд авто замын салбарт ХАБЭА-н хуулийн улсын үзлэг зохион байгуулах удирдамж баталагдан гарсаны дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 07 сарын 06 өдрийн А/393 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг “Талын зам” ТӨҮГ газар болон орон нутагт зарласан тендерт шалгарч Баруун-Урт сумын 4-р тойргийн авто зам тавих ажлыг гүйцэтгэж буй “Ханан салхит” ХХК-дад ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 09/15-наас 09/25-ны хооронд зохион байгуулан явууллаа.

2020 оны 09 сарын 07-ний өдрөөс 09 сарын 09-ний өдрийн хооронд Түмэнцогт суманд туршлага судлах арга хэмжээг мэргэжилтэнүүдтэй хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд оролцогч сумдын болон газрын мэргэжилтнүүдэд ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах цэг болон , санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн үйл ажиллагаатай танилцуулсан.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдсан иргэд ургацаа хураан авлаа. Үүнд: төмс 915,6 кг, сонгино 59,4 кг, лууван 47,3 кг, манжин 12,8 кг, байцаа 76,2кг, помидор 18,8кг хураан аваад байна. Мөн 4 сумаас ургац хураалтын тайлан мэдээг авч нэгтгэсэн. Үүнд төмс 6830кг, лууван 176кг, сонгино 264кг, манжин 540кг байцаа 10 кг, чинжүү 17кг тус тус хураан аваад байна.

Байгууллагын албан хаагчид нийт төмс 958 кг, манжин 11кг, лууван 9кг, сонгино 78,5кг, чинжүү 2 кг, байцаа 10кг огурци 93 кг хураан аваад байна. 2020 онд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэдтэй холбогдон тайлан мэдээг авч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт 71 иргэний 15,856.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг төвлөрүүлж программд оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнээс шүүхэд шилжүүлсэн хугацаа хэтэрсэн 7 иргэний 6,170.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан. ХЭД төсөл хөтөлбөрт анхан шатны баримт материалд хяналт хийн 18,217.4 мянган төгрөгийг зарцуулсан.

Сангийн гүйцэтгэлийн мэдээг, хөрөнгө мөнгө зарцуулах тушаал, шийдвэрүүд, 2021 оны төсвийн төсөл, мэдээллүүдийг байгууллагын мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн сайтад байршуулан иргэд олон нийтэд мэдээллийг ойлгомжтой, түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлж ажиллаж байна.

Дэлхийн банкнаас хэрэгжиж байгаа “ Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөр”-ийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн арга хэмжээний сарын мэдээг гарган хүргүүлсэн. Төрийн банкаар зээл авсан 11 төслийн 17 ажлын байрны мэдээллийг харицсан мэргэжилтэнд гарган өгч LMIS программд шивэлт хийлгэсэн.

Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хяналтаар Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдад ажилласан. Мөн Уулбаян, Халзан сумын мэргэжилтний ажлыг хүлээлцэхэд хэлтсийн дарга болон мэргэжилтэн ажлын хэсэгт орж ажилласан

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Төр хувийн хэвшлийн зөвлөлийн анхдугаар чуулганд 9/17-18 өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулагдахад хэлтсийн дарга оролцсон. Мөн Улаанбаатар хотод 2021-2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн ажлын хэсгээс зохион байгуулсан хэлэлцүүлэгт, Швейцарын хөгжлийн агентлагын санхүүжилтээр хэрэгжиж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс орон нутагт Ментор бэлтгэх сургалтанд 2 бизнес эрхлэгчтэй хамтран оролцсон.

Нийгмийн халамжийн талаар: 2020 онд нийгмийн халамжийн орон нутгийн төсвөөс 124546.0 мян. төгрөг төгрөгийг, улсын төсвөөс 9682166.0 мян. төгрөг нийт 9806712.0 мян төгрөгийг зарцуулагдахаар тусгагдсан байна.

Энэ сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 2480000,0 мян.төг, тэтгэмжинд 863000.0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 589384.0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 120000,0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 301000,0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 1006744, мян.төг, алдарт эхийн одон 680200,0 мян.төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 20600,0мян.төг, насны хишиг 203740,0 мян.төг, цалинтай эхийн тэтгэмж 160166,0 мян.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 98400,0 мян.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 40000,0 мян.төг, орон нутгаас 70800,0 мян.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгоод байна.

Ахмад настан үзүүлэх үйлчилгээнд 65 иргэний 10200,0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 10 иргэний 900,0 мян.төг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан 20 иргэний 5100,0 мян.төгрөгийн баталгаажуулалтыг хийж, санхүүгийн программд хөрвүүлэв.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан 186 өрхөд цаасан эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлж буй Асгат, Дарьганга, Наран, Уулбаян, Түвшинширээ, Халзан сумдын гэрээт 6 хүнсний дэлгүүрийн үйлчилгээг цахим картруу шилжүүлэх бэлтгэл ажил хангагдан 10 дугаар сараас цахим картаар хүнсний бүтээгдэхүүнийг олгож эхлэхээр боллоо.

Хүнсний цахим талоны шинэчлэлийг татан авч тулгалт хийн Баруун-Урт сумын 658 өрхийн 3055 иргэний 73.856.000 төгрөг, Баяндэлгэр сумын 62 өрхийн 285 иргэний 7.376.000 төгрөг, Мөнххаан сумын 88 өрхийн 399 иргэний 9.648.000 төгрөг, Онгон сумын 52 өрхийн 236 иргэний 6.016.000 төгрөг, Түмэнцогт сумын 51 өрхийн 238 иргэний 6.048.000 төгрөг, Сүхбаатар сумын 84 өрхийн 442 иргэний 11.216.000 төгрөг, Эрдэнэцагаан сумын 148 өрхийн 708 иргэний 17.200.000 төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн. Баруун-Урт сумын 1,3,5,7,8,9-р багийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч 490 өрхийг баг тус бүрээр хувиар гарган олголтыг бичиж баталгаажууллаа. Хувийн хэрэгт иргэний үнэмлэх хугацаа дууссан, 16 насанд хүрээд иргэний үнэмлэх авсан, шинээр төрсөн зэрэг 56 иргэний бичиг баримтын баяжилтийг хийсэн.

Аймгийн ахмадын хороотой хамтран 100 ахмадад 9000000 төгрөгний өдрийн үйлчилгээг үзүүлэхээр гэрээ байгуулсан. Одоогоор Түмэнцогт суманд 20 ахмадад 1800000 төгрөгийн өдрийн үйлчилгээг хэрэгжүүлсэн.

Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газраас зорилтот өрхүүдэд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Нэг өрхөд "Нэг дүрэмт хувцас аян" – ы хүрээнд Баруун-Урт сумын "Өсөхдэлгэр ундрах" ХХК цэцэрлэгийн 1 хүүхдэд 70000 төгрөгний хичээлийн багц, "Хаан жимс" БГБХН 7 хүүхдэд гутал, тамирын өмд, "Баялагийн ундрах Баруун-Урт" ХХК 2 хүүхдэд 95000 төгрөгний дүрэмт хувцас, "ИТМТ" ХХК /Ганга/ 1 хүүхдэд 60000 төгрөгний дүрэмт хувцас, гардууллаа.

Түмэнцогт суманд: Зорилтот өрхийн нэг хүүхдэд 40000 төгрөгний тамирын хослол 2 хүүхдэд тус бүр 50000 төгрөгний цүнх, хичээлийн хэрэгсэл нийт 140000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Наран суманд: "НЭГ ӨРХӨД -НЭГ ДҮРЭМТ ХУВЦАС" аяны хүрээнд зорилтот 4 хүүхдэд дүрэмт хувцас, цэнхэр цамц, цүнх, цэцэрлэгийн насны 4 хүүхдэд хичээлийн хэрэгсэл нийт 432600 төгрөгийг зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах хамтарсан багийн батлуулсан төсвөөс зарцуулсан.

Халзан суманд: Зорилтот өрхийн 5 хүүхдэд 100000 төгрөгийн дулаан хувцас олгосон.

"Нэг дүрэмт хувцас аян"-аар нийт 4 сумын 27 хүүхдэд 897600 төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 09 сард 2 удаа хуралдаж 22 хүүхэд орж 18 - хүүхэд асаргаа сунгагдаж, 3 - хүүхэд асаргаа шинээр тогтоосон , 1 сургуульд ирж очих унааны зардал олгуулах шийдвэр гаргаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд 4 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 10 ээжид "Монгол өрх" сэтгэлзүйн хүрээлэнгийн сэтгэлзүйчээр бүлгийн сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс"-ын бүрэлдэхүүнд ажиллаж, Халзан сумын цэцэрлэг, Түвшинширээ сумын соёлын төв, "Цагдаагийн 20 айлын орон сууц", 16 давхар үйлчилгээний барилгад тус тус хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдсэн эсэхэд үнэлгээ хийж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу бүрэн хараагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлж 22 иргэнд 10.0 сая төгрөгийн тусгай хэрэгслийг олголоо. Тусгай хэрэгслийг өөрсдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолтоор олгосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувиллын 14, 15 дугаар ээлжинд 80 ахмад настныг 54 ахмад настныг амруулж, бариа засал, бумба, төөнүүр, цахилгаан массажны аппарат, хаш чулуун ор, шарлага зэрэг сэргээн засах эмчилгээнүүдийг хийсэн.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 28-ний 96 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгох тогтоол гарч Сүхбаатар аймгийн хэмжээнд 23339 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 23121 буюу 99% нь хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 09 дүгээр сард шинээр төрсөн 100 хүүхэд хүсэлтээ гаргаж бүртгэгдэж хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хамрагдаж байна.

Төрийн үйлчилгээг цахим системд нэвтрүүлэх Засгийн газрын ...тоот тогтоолын дагуу нийгмийн халамжийн 6 үйлчилгээг 2020 оны 09 дүгээр сараас эхлэн шилжүүллээ.

Цалинтай эх, жирэмсэн эхийн тэтгэмж, өрх толгойлсон эх/эцэгт/ олгох тэтгэмж, ихэр хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж, насны хишиг, алдарт эхийн одонгийн үйлчилгээ авагч 11420 иргэнээс 10091 иргэний дансыг е-халамж системд бүртгэж, дансжуулах ажлыг 88,9% -тай гүйцэтгэсэн.

Дансгүй иргэдийг дансжуулах чиглэлээр сумдын засаг даргын тамгын газар, багийн засаг дарга, арилжааны банкуудтай хамтарч ажиллаж байна.

2020 оны 09 сарын 17-18-ны өдөр Асгат суманд томилолтоор ажиллаж иргэдийг E-NALAMJ системд бүртгэх иргэдийг дансжуулах “Хаан” Төрийн” банкнаас дансыг авч програмд бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

JCI олон улсын төслийн байгууллагын “ӨРХ ТӨСӨЛ”-ыг аймагт нэвтрүүлэхээр төслийн багийнхныг хүнс тэжээлийн дэмжлэг тусалцаа хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нарын хамтаар хүлээн авч зорилтот өрхийн өмнө нь төсөл авч байгаагүй гэрээрээ бичил бизнес эрхэлдэг 7 –н өрхөөр оруулж хийж буй үйл ажиллагаатай нь танилцуулсан. Мөн өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг санал болгож ажилласан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Улсын төсвийн 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-ийн Халдварт сүрьеэгийн эмнэлгийн дээврийн засвар, ЭМСХХ-5 төслийн 800 сая төгрөг, орон нутгийн 67.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-ийн ариутгалын тасгийн засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийсэн. Мөн улсын төсвийн 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Онгон сумын сум дундын эмнэлгийг унтуулгын аппаратаар хангалаа.

Шадар сайдын 08 дугаар тушаалын дагуу Коронавирусын халдварын түргэвчилсэн 2 дахь шатны үнэлгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж өндөр эрсдэлтэй үнэлэгдэж зөвлөмж боловсруулан аймгийн Онцгой комисст хүргүүлэхэд бэлэн болгоод байна.

06-23 сартай хүүхдийн Олон найрлагат бичил тэжээлийг 15,921,600 төгрөгийн санхүүжилтээр сум, Өөхийн ЭМТөвүүдэд 5136 ширхэгийг хуваарилан тараасан.

Явуулын хэлбэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх баг Түмэнцогт, Мөнххаан, Уулбаян сумдад ажиллаж нийт 745 иргэнийг 5-8 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт, шинжилгээнд давхардсан тоогоор 5364 иргэнийг хамруулж зөвлөгөө өгч ажилласан байна. ДОХ/БЗДХ-ын шинжилгээнд нөхөн үржихүйн 15-49 насны 3659 иргэнийг хамруулж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлж байна.

ТТТӨ, КОВИД-19 –ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр 15 Сургууль цэцэрлэгийн эмч нарт 6 сэдвийн хүрээнд мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 35 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Цайрт минериал, Эм эл Цахиурт овоо уул уурхайн компаниудад Засгийн газрын 213 дугаар тогтоолын дагуу БНХАУ-аас 65 ажиллах хүч ирж ажлын байранд тусгаарлах бэлтгэл

бэлэн байдлыг хангуулах болон лабораторийн шинжилгээг 3 удаа хийж, заавар зөвлөмж өгч, хянан ажилласан.

“ Чадавхитай баг – Чанартай тусламж” сэдэвт ажил мэргэжлийн уралдааныг Дарьганга суманд ЭМГ, АНЭ, Замын Цагдаагийн газар, Авто тээврийн газрууд хамтран зохион байгуулж 14 өрх, сумын эрүүл мэндийн төвийн 45 эмч эмнэлгийн мэргэжилтэнг оролцуулсан.

“Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны нээлтийг арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж, анхан болон лавлагаат шатлалын 150 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион байгуулж байна.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Улсын бүртгэлийн чиглэлээр: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-175, анхны бүртгэл-24, өмчлөх эрх шилжих гэрээ-23, барьцааны гэрээ-114, бүртгэлд өөрчлөлт оруулах -1 лавлагаа хуулбар-9, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-48,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-170, анхны бүртгэл-15, өмчлөх эрх шилжих гэрээ-30, барьцааны гэрээ-101, бүртгэлд өөрчлөлт оруулах -6, лавлагаа хуулбар-3 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-51, нийт бичигдсэн лавлагааны тоо-3

Хуулийн этгээдийн бүртгэл: 08 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1204. Үүнээс ХК-1, ХХК-630, төрийн бус байгууллага-118, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -21, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-137, нөхөрлөл-76, хоршоо-79, хадгаламж зэлийн хоршоо-4, сан-3, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-43, шашны байгууллага-13, хэвлэл мэдээллийн байгууллага-2 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-423, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-63, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-201, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 458, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон - 425, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 177 –г тус тус бүртгээд байна. Тухайн сард лавлагаа нийт 7-г олгосноос Хууль хяналтын байгууллагад 6, иргэн хуулийн этгээдэд 1 лавлагааг тус тус олгосон байна.

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 08 дугаар сарын байдлаар нийт 140 төрөлт, гэрлэлт 34, гэрлэлт цуцлалт 6, үрчлэлт 1, эцэг тогтоолт 9, овог нэр өөрчлөлт 7, нас баралт 35, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 184, үндэсний энгийн гадаад паспорт 5, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 96, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 273 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр: Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2020 оны 09 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 11 ялтны 42470,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 110 ялтны 96650,0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 103 ялтны 81970,0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 18 ялтны 57150.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх урьд оны үлдэгдэл 7 ялтны материал дээр шүүхээс шинээр 22 ялтны 8910 цагийн ялын материалыг хүлээн авч, 9 ялтны 4119 цагийг хорих ялаар солиулж, 1 ялтны 320 цагийг шүүхээс хүчингүй болгож, 25 ялтны 11040 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 4 ялтны 1474 цагийн ял эдлэлтэд хугацаа тавин ажиллаж байна.

Эрх хасах ялын урьд оны 24 ялтны 15758 хоногийн үлдэгдэл дээр 10 ялтны 10950 хоногийн материал нэмэгдэж, 2 ялтны 7241 цагийг үндсэн ялаа эдэлж дууссан үндэслэлээр нэмэгдэж, үлдэгдэл 26 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 2 этгээдийн 10000,0 төгрөг материал дээр шүүхээс шинээр 32 этгээдэд холбогдох 35212,2

нийт 45212,2 төгрөгөөс 23 этгээдийн 16686,5 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Нийт 690 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаас:Төлбөрийн биелүүлбэл зохих 419 гүйцэтгэх баримт бичгийн 2717819.0 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 204 гүйцэтгэх баримт бичгийн 465105.5 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 51.7 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 270 гүйцэтгэх баримт бичгийн 783,488,2 мянган төгрөгийн тэтгэлгийг төлүүлэхээс 178 гүйцэтгэх баримт бичгийн 384,392,0 мянган төгрөгийн тэтгэлгийг хэсэгчлэн төлүүлж, тэтгэлэг бүрэн төлөгдсөн 9, тэтгэлэг авагчийн хүсэлтээр-15, талууд эвлэрсэн-5 нийт 29 гүйцэтгэх баримт бичгийн 71034,4 мянган төгрөгийн тэтгэлгийг бүрэн төлүүлж дуусгавар болгон 241 гүйцэтгэх баримт бичгийн 328,062,1 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрт ажиллагааг явуулж байна.

Шүүхийн шинжилгээний алба: Аёááíú áèà á¿äýèäýä¿¿í Öááááááééí äáçäúí øóöäáé äèááíú á¿äýèäýä¿¿íä íðæ äæðèèáí æèæ¿¿ðð 12 óááá äáä÷ äæðèèáñíááñ öóèááéí äýðäééí äóóæáááíä 0 óááá, çàí äýúäðééí ñèúí äóóæáááíä 1, äýúäðééí äýðúäñèèéí íð 1 ширхэг, íðéö 1 öè íð äèð¿¿èæ, áýðæ¿¿éýí äóðááí ääèäá.

Öóñ äèááíú øèíæýý÷ ýì÷ íäð íú 09 дүгээр сарын ááèáäáäд хүний биед áýìðèèéí çýðýä öíäöñð ¿çèýä 30 óááá ðèèñíýýñ ä¿íä-0, ä¿íäýäöýð-3, ä°íä°í-6, áýìðèèéí çýðýäð ääíääðäðä¿é-11, áýìðèèéí çýðýä öíäöñíäííä¿é-10 ä¿äíýèð ääðäáñäí äáéíä.

Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Хөдөө аж ахуйн салбарт: Өвөлжилтийн бэлтгэл ажил хангахтай холбогдолтой Засгийн газрын 19-р тогтоол, Аймгийн Засаг даргын 04 дүгээр албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай, Зөвлөмж хүргүүлэх тухай А/209 тоот албан бичгийг сумдад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын 343 дугаар тогтоолын дагуу үндэсний үйлдвэрлэлд хонь, тэмээний ноос бэлтгэн тушаасан 5169 малчин, мал бүхий иргэдийн урамшууллын материалыг хүлээн авч, программд оруулсан.

Аймгийн малын тоо, сүргийн бүтэц, өвс тэжээлийн хангамжтай уялдуулан 2020-2021 онд өвөлжүүлж, хаваржуулах болон хэрэгцээлэх малын судалгаа сум тус бүрээр гаргаж мөн аймгийн хэмжээнд эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн судалгааг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлсэн.

Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн зурвас газар, улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг, орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тоон судалгааг гаргаж нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлэн ажилласан.

Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв, Тогтвортой ноос ноолуурын эвсэлтэй хамтран 2020 оны 09-р сарын 07-ны өдөр Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулсан “Ноос бэлтгэх, ангилан ялгах чадамжид суурилсан сургалтанд” МҮА-н мэргэжилтэн хамрагдаж сургагч багшийн гэрчилгээ гардан авсан.

2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гаргасан гүн өрмийн худаг хүлээж авах ажлаар Халзан, Онгон, Баяндэлгэр, Уулбаян, Түмэнцогт сумдад ажиллаж байна.

2020 оны ургац хураалтын явц

Дүгээр дугаар	Таримлын	сан тал бай	сан тал бай	шил хаях тал бай	Ургац хураалт
---------------	----------	-------------	-------------	------------------	---------------

	төрөл					Хураасан талбай /га-аар/	Нэгжийн ургац /цн-ээр/	Хураан авсан ургац/тн-оор/	Ургац хураалтын хувь
1	Улаанбуудай	1510			1510	1150	13	1495	76,1
2	Бусад үр тариа	500			500	250	13	260	52
3	Тосны ургамал	3380			3380	1030	0,3	309	30,8
4	малын тэжээл	502			502	450	56	1892	90
5	Төмс	68,9			68,9	63	92	579,6	91,4
6	Хүнсний ногоо	46,3			46,3	42	82	344,4	90,7
7	Дүн	6007,2			6007,2	2985		4880	49,6

2020 оны ургац хураалтанд орон нутгийн МСҮТ-ийн оюутанууд хамрагдаж 3 ээлжээр 14 хоногийн хугацаатай ургац хураалтанд ажиллаж байна.

“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулсан.

Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 2 аж ахуй нэгжээс нийт 8000 боодол өвс худалдан авах гэрээ хийж баталгаажуулсан.

Мал эмнэлгийн газар: Монгол улсын Ерөнхийлөгчөөс БНХАУ-д шинэ коронавирусын халдвартай тэмцэхэд зориулан хандивласан 30 мянган толгой хонины 8000 хонийг Сүхбаатар аймгийн сумдаас бэлтгэх, малын эрүүл мэндийн үзлэг хийн, лабораторийн шинжилгээнд хамруулах, мал бэлтгэх цэгт суурилан бүртгэлжүүлэх, хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлэх, хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангуулах, бэлтгэсэн хонийг Замын-Үүд дэх байгууламжид хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүний дагуу МЭЕГ-ын МАЭМХГ-ын дарга Т.Тунгалаг, тус газрын ахлах мэргэжилтэн С.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн тус аймагт ажиллаж байна. Энэ хүрээнд 8000 мян.тол хонийг Сүхбаатар аймгийн сумдаас бэлтгэх ажлын хэсгийг 2020 оны А/508 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсэгт багтсан Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, ХХААгазар, сумдын Засаг дарга нарт “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлсэний зэрэгцээ хонь бэлтгэх болон хорио цээрийн бүсэд ажиллах бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж байна. Уг ажилд МЭЕГ-аас 3 удирдах ажилтан, аймгийн мал эмнэлгийн газраас 7 удирдах ажилтан, мэргэжилтэн, лабораторийн 33 шинжлэгч эмч /давхардсан тоогоор/, сумын МЭТ, ХАА тасгаас 33 мэргэжилтэн, хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 31 эмч, багийн засаг дарга 36, туслах ажилтан 42, жолооч /хонь цуглуулахад/ 36, ачаа тээврийн 46 жолооч, “UB food Mongolia” ХХК-ний 13, аймгийн хэмжээнд нийт 280 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Баяндэлгэр сумын хорио цээрийн бүсэд 1193 хонь, Халзан сумын бүсэд 511 хонь, Түвшинширээ сумын бүсэд 534 хонь, Онгон бүсэд 2025 хонь, Дарьганга сумаас 983, Наран сумаас 577, Уулбаян 488, Баруун-Урт сум 578, Эрдэнэцагаан сум 1080, Мөнххаан 227, нийт **8196** толгой хонийг малчдаас цуглуулаад байна. Сумдын хорио цээрийн бүсэд цуглуулсан 5777 толгой хонинд бруцеллёзын шинжилгээг хийж, гарал үүслийг мал эмнэлгийн цахим системд оруулан 24 удаагийн явалтаар 5777 толгой хонийг тээвэрлэн Дорноговь аймагт ажиллаж буй МЭЕГ-ын ажлын хэсэг болон тус аймгийн МЭГ-аас ирүүлсэн мал хүлээн авах, хорио цээр, тусгаарлалтын бүсэд маршрутын дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумаар дамжуулан Замын-Үүд суманд хүлээлгэн өгөөд байна.

Баруун-Урт сум 578, Эрдэнэцагаан сум 1080, Уулбаян сум 488, Мөнххаан 227, нийт **2373** хонийг ээмэгжүүлэн лабораторийн шинжилгээ хийгдэж байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: 09 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулагдсан зүүн бүсийн төр, хувийн хэвшлийн анхдугаар чуулга уулзалтад Сүхбаатар аймгийн ТХХЗөвлөл 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцож ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/535 дугаар захирамжаар 4 аж ахуй нэгжийн согтууруулах ундаа худалдах хүсэлтийг сунгаж, 1 аж ахуй нэгжид худалдах эрх шинээр олгосон байна.

“Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн багаас жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн хог хаягдлын судалгаа хийх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх зорилгоор мах, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, эрчимжсэн аж ахуй зэрэг үйлдвэр эрхлэгчдийн 8 аж ахуй нэгжийн төлөөллийг судалгаанд хамрууллаа.

09 сарын 15-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо "ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" уриан дор зохион байгуулагдсан "НАМРЫН НОГООН ӨДРҮҮД" үзэсгэлэн худалдаанд аймгийн 2019 оны " Шилдэг сав баглаа боодол"-той бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Халзан сумын иргэн Ц.Идэрбат, "Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч "Шүүт" малчны бүлгийн гишүүн С.Баярсайхан, Г.Уянга, Р.Гантуяа нэр сүү, сүүн бүтээгдэхүүнээр, "Шилдэг бренд бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч иргэн М.Батжаргал Хоол амтлагч /тааны сорс/, аймгийн аварга тариаланч Сүхбаатар, Мөнххаан сумын иргэн Д.Оюундарь, Б.Оюунгэрэл нар хүнсний ногоогоор тус тус амжилттай оролцож, сургалтад хамрагдаж, туршлага судаллаа.

Үзэсгэлэн худалдаанд оролцсон 21 аймгийн 200 гаруй хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдээс Халзан сумын М.Батжаргал захиралтай "АРИУН ХАТАВЧ" ХХК-нийн үйлдвэрлэсэн Хоол амтлагч / тааны сорс/ "ОРОН НУТГИЙН ШИЛДЭГ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН-2020" номинацид "ТЭРГҮҮН БАЙР" эзэлсэн амжилт гаргалаа. 2012 онд тус аймгийн Баруун-Урт сумын Улсын тэргүүний " Алтанцацал хоршоо" "Шилдэг тариаланч"-аар, 2013 онд тус сумын "Сүхбаатар хүнс" ХХК-ний "Ган-Эрдэнэ" цехийн үйлдвэрлэсэн Адууны утсан мах " ОРОН НУТГИЙН ШИЛДЭГ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр шалгарч байсан бол 7 жилийн дараа улсад 3 дах удаагаа тэргүүлж шагнагдлаа.

Уул уурхайн салбарт: Мерит төсөлтэй хамтран “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур” сэдэвт сургалтыг 09 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулж 6 сумын төрийн байгууллага, иргэд, уул уурхайн компанийн нийт 40 гаруй төлөөллийг оролцуулсан.

09 дүгээр 07-11-ний өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мерит төслөөс санаачилсан салбарын яам, агентлагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай танилцах, зөвлөмж чиглэл өгөх, туршлага судлах уулзалт, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын Уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтнийг оролцуулсан.

Аймгийн Засаг даргын захирамжаар уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй Монголжүюаньли, Дорнын хүдэр ХХК-иудаас ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг үндэслэн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн чиглэлийг түр тогтоосон.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/539 дүгээр захирамжаар Түмэнцогт сумын нутагт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эф Жи Пи Эм” ХХК-ийн уурхайн тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг тогтоосон.

Зам тээврийн салбарт: Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй аймгийн төвийн 4-р тойргийн 9,1 км хатуу хучилттай авто зам, замын байгууламж, 3-р багт баригдаж байгаа 1,1 км хатуу хучилттай авто зам, 1-р багийн “60, 24 айл”-ын гаднах зам талбайн ажлын явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Алсын хараа 2050, Иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-т тусгагдсан ажлыг

хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутагт жижиг онгоц, нисдэг тэрэгний үйлчилгээ нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх талаар аймаг, орон нутгийн дэмжсэн саналыг Иргэний нисэхийн ерөнхий газарт уламжилсан, түүнчлэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 09-ны 170 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн биелэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлээд байна.

Инженерийн шугам сүлжээ өргөтгөх, авто замын байгууламж дагуу үйлчилгээний байгууллагууд гадна талбайд зогсоол, гарц гаргах хүсэлт ирүүлсэн 4 аж ахуй нэгж, иргэнээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг аймгийн Засаг даргын 2019 оны А/627 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээр хэлэлцэн холбогдох зөвшөөрлийг олгон ажилласан.

Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил:

Мэргэжлийн хяналтын газар: Тус газраас МХЕГ-ын даргын баталсан 01/96 тоот удирдамжийн дагуу бүх шатны боловсролын байгууллагуудын 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, онцгой нөхцөлд сургалтын үйл ажиллагааг эхлүүлж байгаатай холбогдуулан Коронавируст халдвар “Covid-19”-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөлтийн байдалд шалгалт хийж мэргэжил арга зүйн удирдлага туслалцаагаар хангаж ажиллалаа. Урьдчилан сэргийлэх шалгалтанд ерөнхий боловсролын 12 сургууль түүний дотуур байр, хоол үйлдвэрлэлийн газрууд 20 цэцэрлэг болон түүний хоол үйлдвэрлэлийн газрууд, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Боловсрол өргөө- 200 хүүхдийн нэгдсэн дотуур байр зэрэг газрууд хамрагдлаа. Шалгалтанд хамрагдсан бүх шатны боловсролын байгууллагуудын ундны уснаас дээж авч лабораторийн шинжилгээнд хамрууллаа.

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын даргын баталсан 17/55 тоот удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Түвшинширээ, Мөнххаан, Уулбаян, Түмэнцогт сумдын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж Цэгээн үүдэн ХХК, Цайртминерал ХХК, Хунша И Жаны ХХК, Эм эл цахиурт овоо ХХК, Нутгийн Анар ХХК, ЭБНЭ ХХК, Сунхунголд ХХК, Монголжүюаньли ХХК, Говьмастер ХХК, Хунт Өгөөж ХХК, Эф жи пи эм ХХК, Мандах инвест ХХК болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.

Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн өргөдлийн дагуу Наран суманд баригдаж байгаа 50 хүүхдийн дотуур байрны барилгын ажил гүйцэтгэж буй Ай ди си пропарти ХХК-ийн барига угсралтын үйл ажиллагаанд шалгалт хийж ЗТХ-ийн дагуу арга хэмжээ тооцож, хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Наран сумын ЗД-аас ирүүлсэн өргөдлийн дагуу Наран сумын сургуулийн халаалтын зуух цоорч цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаарх улсын байцаагчийн дүгнэлт гаргахаар ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Асгат, Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт байгалийн хадлан тэжээл бэлтгэж байгаа 3 иргэний хадлан бэлтгэж байгаа үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Мөн аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн “Зөрчлийн хэрэг харьяаллын дагуу шилжүүлэх” 3 материалыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Аймгийн ЗД-ын захирамжаар баталсан ажлын хэсэг дотоод тээвэрлэлт эхлүүлэх хүсэлт ирүүлсэн Бадмаараг хаш ХХК, Олгойбулаг ХХК, Премиуммүкөөл ХХК-уудын тээвэрлэлийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, холбогдох зөвлөмж зөвлөгөө өгч, тээвэрлэлтийн талаар улсын байцаагчийн дүгнэлт гаргалаа.

Мөн иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу Бичигт дэх авто замын шалган нэвтрүүлэх хилийн боомтоос Петровичайна дачин тамсаг ХХК-ийн 19 дүгээр талбай хүртэлх авто замын дагуу 27 км-т иргэн Орломжав, 30 км-т байрлах иргэн Шарваагийн газрын тосны жолооч нарт хоол хийж бөөгнөрөл үүсгэн халдвар хамгаалал, хорио цээрийн дэглэм зөрчигдөж байсан 2 иргэний гэрийг буулгуулж, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ашиглалтыг түр зогсоох тухай Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2020 оны 09 сарын 16-ны өдрийн 01, 02 дугаартай тогтоол гаргуулж, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж арга хэмжээ тооцож ажиллалаа.

Петрочайна дачин тамсаг ХХК болон тээвэрлэлт гүйцэтгэж буй 2 ААНБ-ын удирдах албан тушаалтнуудад газрын тосны жолооч нар нь замд байгаа айл хоол идэж, бөөгнөрөл үүсгэн халдвар хамгаалал, хорио цээрийн дэглэм зөрчсөн талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, зөрчлийг нэн даруй арилгах үүрэг чиглэл өглөө.

Петрочайна дачин тамсаг ХХК-ийн тээвэрлэлт хийж буй замын нөхцөл байдалд улсын байцаагч шалгалт хийж хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Сүүлийн 28 хоногт Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын албан ёсны цахим хуудсаар цаг үеийн мэдээ мэдээлэл 19863 хүнд хүрсэн байна.

Тус лаборатори нь Аж ахуй нэгж, иргэн , улсын байцаагчийн төлөвлөгөөт болон албан хүсэлтийн сорилт шинжилгээг хими хор судлал, нян судлал, таримал ургамал үр хорио цээрийн чиглэлээр хүнсний бүтээгдэхүүн, унд ахуйн ус, жимс жимсгэнэ, хүнсний ногоонд нийт 111 сорьцонд 416 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс 21 сорьц нь эерэг дүнтэй гарсан байна.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил:

Баруун-урт:

Байгалт орчин, дэд бүтэц, газар зохион байгуулалтын чиглэлээр: Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт байрлах боловсрол хорооллын дундах зам талбайн тохижилт, тоглоомын талбай барих ажлын тендерт “Шинэ соёл констракшн” ХХК шалгарч гэрээ байгуулан тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн суманд хүлээлгэн өгсөн.

Мандал хорооллын хойд талын айл өрхүүд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн тохижилтын ажлыг “Дөрвөлж” ОНӨТҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Ажлын явц 80 хувьтай байна.

Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайн шарилж устгах ажлын тендерт “Билэгт тусч хүү” нөхөрлөл гэрээний дагуу хувиартай талбайн хог ургамал шарилжийг устгах ажлыг хийж гүйцэтгэж байгаа ба ажлын явц 70 хувьтай, хуваарьт талбайн шарилж устгах ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн бүх багийн нийтийн эзэмшлийн зам талбайн шарилж устгах ажлыг багийн ажлын алба, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ хамтран ачилт хийх цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайд ангилан ялгах хогийн сав байршуулах, иргэдэд хогийн ангилах ялгах талаар сургалт сурталчилгааны багш бэлтгэх мэдээлэл өгөх ажлыг хамтран гүйцэтгэж, тусгай зориулалтын 4 газрыг сонгон ангилан ялгах хогийн сав байршуулсан.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: Монголиа Ази рийч ОУБ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзлэг зохион байгуулсан. Тус үзлэгт 55 хүүхэд хамрагдсан бөгөөд 7 хүүхдийг Улаанбаатар хотод эмчлүүлэхээр болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 77 ээжид зөвлөгөө өгч ажилласан. Мөн Монголиа Ази рийч ОУБ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг тус сумын 11 дүгээр цэцэрлэгт олгохоор боллоо.

Боловсрол, соёлын чиглэлээр: Багш нарын баярыг тохиолдуулан боловсролын салбарын байгууллагуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг 2 өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 15 байгууллагын 200 гаруй баг тамирчид оролцсон бөгөөд багийн дүнгээр 1 дүгээр бүрэн дунд сургууль шилжин явах цомын эзэн болсон.

Баяндэлгэр:

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Хүүхдийн цэцэрлэг: 2020-2021 оны хичээлийн жилд Аймгийн нэгдсэн эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран цэцэрлэгт хамрагдаж байгаа нийт хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэг хийж, цагаан хорхойн шинжилгээнд хамруулан, хүүхдийн суралцах эрүүл таатай орчинг бүрдүүлж анги танхимаа тохижуулан бэлтгэл ажлыг бүрэн ханган нийт 2

настай 40, 3 настай 45, 4 настай 61, 5 настай 100 нийт 246 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

ЕБСургууль: Сумын онцгой комисс болон "Байшинт- Ойл"ХХК сургуулийн захиргаанаас нийт багш, ажилчид, сурагчдад хичээлийн хэрэгсэл, маск, гар ариутгалын бодисоор дэмжлэг үзүүлэв.

Эх хэлний өдөр"-т зориулж Монгол хэл, Түүх- Нийгмийн судлагдахууны багш нар хамтарч бичиг үсэг, түүх соёлын дурсгалаа таниулах, сурагч шавь нартаа байгаль эх дэлхийгээ хайрлах хамгаалах үзлийг түгээх аялал зохион байгууллаа

Соёл: МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу улс орон даяар явагдаж буй "Хязгааргүй ном сэтгэлгээний эрх чөлөө" сэдвийн дор зохион байгуулагдсан "Номын баяр"-2020 үйл ажиллагаанд орон нутгийн зохиолчдын болон ховор номын үзэсгэлэн гаргаж сумын номын санг танилцуулах,сурталчлах нэгдсэн арга хэмжээ мөн сургалт семинарт хамрагдлаа. Мөн номын санд ном хандивлах аяныг 10 сарын 26-ны өдрийг дуустал зохион байгуулж байна.

Соёлын яамны сайдын тушаалын дагуу зохион байгуулагдаж байгаа "Соёлын цаг" нөлөөллийн аяны хүрээнд Соёлын төвийн болон номын сангийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах, номын үзэсгэлэн гаргах зэрэг ажлуудыг хийж байна.

Эрүүл мэндийн төв: ЕБС-ийн 9-12-р ангийн 114 охиныг охидын үзлэгт хамруулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан ба ЕБС-ийн 2-5 анги, 9-12 ангийн сурагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн.

Хөдөө аж ахуй, байгаль орчин "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслөөс тус суманд энэ сарын 13,14 нд Түвшинширээ, Эрдэнэцагаан , Баяндэлгэр сумдын БАМБ-ийн гишүүдийг хамарсан сургалт зохион байгуулсан. Уг сургалтад тус сумаас 12 малчныг хамруулж тэдгээрийг мал аж ахуйн эрсдлийг бууруулах, өрхийн орлого бүрдүүлэх, малчдын болон хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлэх талаар мэдээлэл өгч,чадавхижуулан гэрчилгээ олгосон.

Монгеофизик ХХК нь Ширээт багийн "Тогмидын хөндий", Дэлгэр багийн "Цахиуртай" гэсэн газруудад худгийн цооног өрөмдөж гаргасан. Өвөлжилт,хаваржилтын бэлтгэлийг хангахтай холбогдуулан малчдын түвшинд 45 тн өвс, 0,3 тн гар тэжээл , 12 тн хужир шүү бэлтгээд байна.

Сумын аюулгүй нөөцийг бэлтгэх хүрээнд иргэн С.Батаатай 2500 боодол өвсний гэрээ хийгээд байна.

БНХАУ-д шинэ короновирусийн халдвартай тэмцэхэд зориулан хандивлах хонинд зориулж 1200 хонь цуглуулсан. Үүнээс 545 хонь Замын үүд сумын хорио цээрийн бүс рүү ачуулсан ба үлдэгдэл 655 хонийг Дөхөм багийн нутаг болох Гурван хашаатад хариулан маллаж байна. Эдгээр цугларсан хонины 298 нь хавар малчдаас короновирустай тэмцэхэд зориулж хандиваар өгсөн хонь болно.

Байгаль орчны чиглэлээр: Ширээт багийн даргатай хамтран сумын төвөөс 5 км -ын радиуст үүссэн эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэн 4 тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн ажиллаа.

Байгаль орчин аялал жуучлалын яамны санхүүжилтээр ХААИСургуулийн багтай хамтран Дөхөм багийн нутаг дэвсгэрт байрлах "Бор толгойн булаг"-ийн эхийг хашиж хамгааллаа.

"Цэнхэр алт усаа хайрлая "сарын аяны хүрээнд усыг хэрхэн ашиглах талаар сургалтыг ахлах бүлгийн 10-р ангийн сурагчдад видео хичээлийг зааж тэдний санал хүсэлтийг ажил үүргийн хуваарьт тусган ажиллаа.

Галба өөш долоодын сав газар аймгийн байгаль орчин аялал жуучлалын газартай зохион байгуулж буй уст цэгийн тооллогонд 2014 оноос хойш шинээр гаргасан 138 худаг борооны усаар тэжээгддэг 87 нуур тойром болон 58 худаг тус тус тоологдоод байна.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын захирамжаар Ахмадын өдөр тэмдэглэх, “Баян намар-2020” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, Сумын Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги байгуулах, сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн ажиллах журмыг батлах, газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулах, “Гэрээр зочлох үйлчилгээ” сэдэвт хөдөөгийн өрхүүдэд мэдээлэл өгөх ажлын хэсэг томилох, БНХАУ-д 30 мянган толгой хонь хандивлахад хандивын хонийг цуглуулах ажлын хэсгийг томилох, хандивын хонийг үзлэг шинжилгээнд хамруулах хорио цээрийн бүсийг байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэв.

УИХ-ын гишүүн Ж. Батсуурь, Н. Ганибал нар 2020.09.17 ны өдөр сумын иргэд хөдөлмөрчидтэй “Талархлын уулзалт”-ыг зохион байгуулж, нийтдээ 200 гаруй хүн оролцож, 10 гаруй иргэн санал хүсэлтээ илэрхийлж үг хэлж, асуулт асууж, зохих хариултыг авсан.

Сургалт сурталчилгааны чиглэлээр: Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 4 багт багийн Засаг дарга нараар ахлуулан, сумын Ахмадын хороотой хамтран хөдөөгийн багийн бүх өрхүүдэд цаг үеийн мэдээллийг дараах чиглэлээр өгч, гарын авлага тарааж, зөвлөмжийг биечлэн хүргэлээ. Үүнд:

а/. “Амьдрал туулсан ахмадын үг” сэдвийн дор өвөлжилтийн бэлтгэл хангах, хориотой ан агнуур, хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн харилцааны соёл, өрхийн хуримтлалын талаар,

б/. Өвөлжих газрын нэр, өвөлжөөнд байрших өрх,хүн, малын тооны судалгааг гаргаж байна.

в/. Авлигын эсрэг үйл ажиллагааг 110 дугаар үнэгүй мэдээлэх нь:

г/. 1072 хувьцааны талаар .

д/. Цэрэг татлага, ахмадын баяр, Баян намар-2020 үзэсгэлэн худалдааны удирдамж

Сүхбаатар аймгийн ОБГ-ын орлогч дарга, хошууч С. Ганбатаар ахлуулсан ажлын хэсэг Дарьганга суманд ажиллаж, сумын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж, үнэлгээ өгч, ЕБС-д эрсдэлийн үнэлгээ хийж, сургалт зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын ёс зүйн улсын зөвлөгөөнд төрийн албан хаагчдын төлөөлөл, байгууллагуудын ёс зүйн зөвлөлийнхнийг цахимаар хамруулсан.

Үйлчилгээний нэгдсэн төвийн операторын үйлчилгээний талаар:

1/. Иргэний үнэмлэхний лавлагаа 25

2/. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийнталаарх тодорхойлолт -3

3/. Гэрлэсний бүртгэлийн лавлагаа -1

4/. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх- 24

5/. Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт 23

6/. Иргэнд олгох тодорхойлолт 22

7/. Жолоочийн лавлагаа мэдээлэл 11

8/. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох тодорхойлолт 1 НИЙТДЭЭ 110 иргэнд үйлчилгээ үзүүлж, төлбөр хураамжид 87000 төгрөгийг төвлөрүүллээ.

Боловсрол: ЕБС нь сумын цагдаагийн хэсэгтэй хамтарч “School police” үйл ажиллагааг зохион байгуулж эцэг эхчүүдэд заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

- Соёлын төвөөс соёлын ажилтны өдрүүдийг тохиолдуулан зохион байгуулсан "СОЁЛЫН ЦАГ" хөтөлбөрийн хүрээнд хүүхэд багачуудын дунд унших аян өрнүүлж, цахимаар богино өгүүллэгийн уралдаан зарлаж, нийтийн эзэмшлийн талбайд "Номын үзэсгэлэн"-гаргасаны зэрэгцээ хүүхдүүдэд музейн үзвэрээр үйлчилсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд зохион байгуулагдсан “Номын баяр”-ын үйл ажиллагаанд сумаас төлөөлөл оролцож 13 сумаас хамгийн олон ном хандивлагч сумаар шалгарлаа.

Багш нарын их хурлаас гаргасан саналын дагуу нийт багш, ажилчдыг Онгон сумын Эрүүл мэндийн төвд багцын үзлэг шинжилгээнд хамруулсан. Хамрагдвал зохих 53 багш, ажилчдаас 52 буюу 98% нь хамрагдсан. Багш нарын их хурлаас саналын дагуу нийт багш, ажилчдыг Онгон сумын Эрүүл мэндийн төвд багцын үзлэг шинжилгээнд хамруулсан.

Эрүүл мэнд: “ Эерэг хандлага- эмчилгээний эхлэл” 3 сарын аян эхлэж ажилчдадаа танилцуулан хүн бүр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ний хавтас нээлгэж, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн дүрэм” 3 удаагийн дотоодын сургалт зохион байгуулсан.

Аймгийн ЭМГазраас 13 сум, 3 өрхийн эмнэлгийн дунд “Чанартай баг- Чадамжтай тусламж” ажил мэргэжлийн уралдааныг 9-р сарын 19-20-ний өдрүүдэд Дарьганга суманд зохион байгууллаа.

Байгаль орчны чиглэлээр: Дарьгангын БЦГ-ын Хамгаалалтын захиргаанаас Орчны бүсийн сумд болох Дарьганга, Онгон, Наран, Асгат, Эрдэнэцагаан сумдын дунд "ШИЛДЭГ ЭКО КЛУБ" шалгаруулах уралдааныг амжилттай зохион байгууллаа.

Тус уралдааны нэгдсэн дүнгээр:

1-р байр Эрдэнэцагаан сумын "Ногоон ирээдүй" эко клуб

2-р байр Асгат сумын "Эко элч" эко клуб

3-р байр Наран сумын "Наран булаг" эко клуб тус тус шалгарлаа.

ЗДТГ-ын БОХУБ нь “Гэрээр зочлох үйлчилгээ” хэлбэрээр ажлын хэсэгт оролцож хориотой ан, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийж, гарын авлага 52 өрхөд гардуулж өгөөд байгаа бөгөөд энэ арга хэмжээг үргэлжүүлэн зохион байгуулна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Хятад улсад бэлэглэх хонийг цуглуулах ажилд 14 хоногт Мал эмнэлгийн тасгийн албан хаагчид, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд ажиллаж нийтдээ 800 орчим хонийг цуглуулан тээвэрлүүлсэн.

Мөнххаан:

Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу 2020 оны орон нутгийн ээлжит сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороодод нийт 66 төрийн албан хаагчид ажиллахаар томилогдон сонгуулийн ажил хуулийн хүрээнд хийгдэж байна.

МУ-ын цэргийн албаны тухай хуулийн 31-р зүйл Улсын их хурлын 2009 оны 33-р тогтоолын 1,2 дугаар хавсралтын дагуу Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлыг аймгийн Цэргийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Нийт 65 иргэн мэдэгдэх хуудсын дагуу ирж мөнгөн төлбөрөө тооцуулж 33 иргэнд мөнгөн төлбөр тавьж 10 сарын 1 ны дотор мөнгөн төлбөрийг аймгийн төрийн сангийн дансанд хийж төвлөрүүлэхээр мэдэгдэх хуудсыг өгөөд байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 48,0 сая төгрөгийн хөрөнгөөр бага оврын автобус нийлүүлэх тендерийг Оточ-Оргил ХХК авч хүлээлгэн өглөө.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: Төл малд бруцеллёзын тарилга 112,0 мянга, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 180,0 мянган төл малыг хамруулаад байна.

БНХАУ-д хандивлах хонийг цуглаах ажил зохион байгуулагдаж байна. Одоогийн байдлаар 167 хонь цуглуулаад байна.

Байгаль орчны улсын байцаагч, багийн засаг дарга нартай хамтарч 4 өрхийн 1100 хонь 200 адуу 80 үхэр отроор орж ирснийг мэдэгдэх хуудас өгч, хилийн цэс гаргах арга хэмжээ авч ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гарах 3 худагт геофизикийн судалгаа хийлгэж координат тогтоосон.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр : 1-р багийн засаг дарга, иргэдийн нийтийн хурлын дарга нар хадлан болон үндсэн тарваганд мониторингийн ажлаар явсан.

3-р багийн нутаг болох Мөнххаан ууланд сэргээн нутагшуулсан тарваганы ичээ нүх-5, Богд уулын үндсэн тарваганы ичээ нүх-15 тус тус тоолж холбогдох мэргэжилтэнд мэдээллийг явуулсан.

Хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан багийн засаг дарга нарт анхааруулах санамж 250 ш-ийг хувиран өгч иргэдэд танилцуулах ажил хийгдэж байна. Түүнчлэн хадлангийн 3 салааны ахлагчдад гал түймрийн анхааруулах санамж өгч ажилласан.

Хөдөлмөр эрхлэлт халамж, нийгмийн хамгааллын чиглэлээр: Албан газрын харьяалалтай 91 ахмад, албан газрын харьяалалгүй 319 ахмадад 6270,0 мян төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан.

Боловсрол: 2020-2021 оны хичээлийн жилд тус сургуульд шаардлагатай байгаа ажлын байрны сул орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалтуудыг зарлаж Монгол хэл Уран зохиолын багш 1, Түүх нийгмийн ухааны багш 1, Бага ангийн багш 1, Эмч /түр/ 1-ийг тус тус ажлын байраар хангаж хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Тус сургуулийн Дотуур байранд хэрэгжихээр болоод буй “Боловсролын чанарын шинэчлэл IV төсөл”-ийн танхим бэлэн болж, үйл ажиллагааг эхлүүлээд байна. Хичээлийн 1-р байран дах ашиглалтгүй танхимыг сэргээн засварлаж “Уншлагын танхим” болгон хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна.

Хуульч, өмгөөлөгч, лектор багш Бат-Отгоныг урьж нийт эцэг эхчүүд, ахлах дунд ангийн сурагчид болон багш нарт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтанд багш нар, 9, 12-р ангийн нийт сурагчид, 100 орчим эцэг эхчүүд хамрагдлаа.

Эрүүл мэнд: Амбулаторийн үзлэг 1150 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 615 байна. Явуулын амбулаторийн үзлэгт двхардсан тоогоор 2279 хүн хамрагдсан. Үүнээс эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 359 хүн хамрагдсан.

Наран:

Аймаг, нийслэл, сум дүүрэг ИТХ-ийн 2020 оны ээлжит сонгууль явуулах сумын сонгуулийн хороо, хэсгийн хороо байгуулагдан ажиллаж байна.

Хамтарсан багаас санаачлан Сүхбаатар аймшгийн “АА”-ийн зөв боломж бүлгэмийн 12 гишүүд урилгаар авчирч “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Хүүхэд хамгааллын анхдагч орчин болох гэр бүлийн болон иргэдийн харилцаа хандлагыг өөрчлөх” сургалтыг зохион байгууллаа.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: Албан байгууллагын харьяалалгүй ахмадуудын нэрсийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж 131 ахмадад хүндэтгэл үзүүлэхээр болсон.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төмс хүнсний ногоо тариалах төслийн ногоо хураалт хийгдэж нийт 250 кг төмс, сонгино 10 кг, шар манжин -20 кг хураан авлаа.

Эрүүл мэнд: ЭМС-ийн 2020-08-21ны А/408 дугаар тушаалаар “Эерэг арга-эмчилгээний эхлэл” 3 сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган арга хэмжээ зохион байгууллаа.

Болосворол, соёлын чиглэлээр: Сүхбаатар аймгийн нийтийн номын сангаас 09 сарын 17,18 –ны өдрүүдэд “Номын баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд номын санчны сургалтанд хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж, номын сангийн үйл ажиллагаагаа сурталчлан туршлагаа таниулсан.

2020-2021 оны хичээлийн жилд нийт 4 ажлын байран дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, 3 удаа шалгалт зохион байгуулсан.

1. Бага ангийн багш
2. Монгол хэл уран зохиолын багш
3. Дотуур байрын багш
4. Насан туршийн багш

Онгон сумын соёлын төвтэй хамтран хилийн 3 дугаар заставын хилчин дайчидад явуулын номын үйлчилгээ, урлаг соёлын арга хэмжээг зохион байгууллаа.

Онгон:

МУ-ын Ерөнхийлөгчийн БНХАУ-д хандивласан 30000 толгой хонь төвлөрүүлэх ажлын хүрээнд сумаас нийт 2001 толгой хонь төвлөрүүлэн бэлэн болгоод байна.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд: Наран, Дарьганга, Онгон сумын сургууль, цэцэрлэгийн багш нарыг багц үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж нийт 112 багш үзлэгт хамрагдлаа.

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан номын өдөрлөгт ЕБСургууль амжилттай оролцож шагналт байр эзэллээ.

Аймгийн ЗДТГазраас зорилтот өрхөд олгох чиглэлээр 10 гэр хуваарилсаны дагуу холбогдох судалгааг гарган тус өрхүүдэд гардуулж өгөхөд бэлэн болоод байна.

Хүүхдийн цэцэрлэг нь багш ажилчиддаа Монгол бичгийн сургалт явуулж мэдлэг мэдээллийг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулж байна. 24 багш ажилчид хамрагдсан байна.

"Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөт ажлын хүрээнд ардын аман зохиолын төрөл зүйлийн нэг "Гэрийн ерөөл"-ийг сурагчдаараа дамжуулан түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд: Хилийн дугаар ангиас хадлангийн нэг салаа, хувиараа хадлан хадаж, 2 салаа Дарьганга, Наран сумдын нутагт хадлан хадаж байна.

Хот суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд төвлөрсөн халаалт, дулааны шугамын засвар үйлчилгээг график гарган засварлах ажил хийгдэж байна. Шинээр 3 аж ахуй нэгжийг дулааны шугамд холбох ажил 80 хувьтай явагдаж байна.

Малчин иргэдээс идэвхитэн байгаль хамгаалагч ажилуулах талаар судалгаа хийж 2 малчинтай гэрээ байгуулан ажиллахаар боллоо.

Сүхбаатар:

Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр; Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүжилтээр Дарханхаан уулын урд тал, Матад сум явах зам дагуу хоггүй монгол аяны хүрээнд хогны талаар сурталчилан таниулах сурталчилгааны 3 самбар байршуулсан.

Иргэд малчдын мэдээллийн дагуу Шинэбулаг багийн Баянөлзийт гэх газарт зөвшөөрөлгүй хадлан бэлтгэж байгаа иргэдийг таслан зогсоож Улсын байцаагчийн зүгээс 013556 дугаартай лацаар лацдаж үйл ажиллагааг нь зогсоосон.

Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: Сумын засаг даргын 2020 оны А/122 дугаар захирамжаар баталсан "Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя" угийн бичгийн уралдааны удирдамжийн дагуу байгууллагын багш ажилчдад 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан.

“НОМЫН БАЯР-2020” аяны хүрээнд “НОМЫН ТЭМДЭГЛЭЛ” ХӨТЛӨХ УРАЛДААН, “ХАМГИЙН ОЛОН НОМТОЙ ӨРХ” БОЛОН, “ХАМГИЙН ХОВОР НОМТОЙ ӨРХ”-ИЙГ шалгаруулах уралдааныг зохион байгууллаа. Нийт 7 өрх хамрагдсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Глобал сангийн дэмжлэгтэйгээр Сүрьеэ өвчнийг илрүүлэх ажлын хүрээнд сумын нутаг дэвсгэр дээр байдаг уул уурхайн компаниудын судалгааг гаргаж хүргүүлэн үзлэг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Судалгаанд Цайрт минераль ХХК, Олгой будаг, Цэгээн үүдэн, Алаг тогоо ХХК зэрэг уурхайн компаниуд хамрагдсан.

СӨБ-ийн 126 сурагч, ЕБС-ийн 347 сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Мөн ЕБС-ийн 8,9 дүгээр ангийн охидуудыг охидын үзлэгт хамрууллаа.

ЕБС-ийн 7,15 настнуудыг сахуу татрангын эсрэг вакцин тарилгад 53/50/94,3% хамрууллаа.

Түвшинширээ:

Цаг үеийн ажлууд: 2019-2020 оны МАА-н болон төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын биелэлтэнд төлөвлөгөөний дагуу хяналт тавин ажиллаж байна. Мөн өөр аймаг сумын нутагт өвөлжих айл өрх, малчдын судалгааг авч байна.

Намрын ээлжит цэрэг татлаганд цэргийн 18-25 насны 95 иргэнд цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл хүргэж ажиллалаа.

Монгол Улсын ерөнхийлөгч Бүгд Найрамдах Хятад Ард Улсад айлчлах үеэр хандивласан 30000 хонийг бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын А/48 дугаар захирамжийг батлан, хорио цээрийн бүсийг сумын төвөөс 20 км зайтай, хүн, малын шилжилт хөдөлгөөн багатай “Шүүтийн ширээ” гэдэг газрыг сонгож байгуулан пайз, тэмдэг, тэмдэглэгээг хийж, ариутгал халдваргүйтгэлийн цэгийг байгуулав. Хорио цээрийн бүсэд Мал эмнэлгийн тасгийн байцаагчаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 14 хоног ажилласан байна. Нийт 5 багийн 127 малчин өрхөөс 537 толгой мал цуглуулсан бөгөөд хонь хандивласан малчинд батламж гардуулан өгөв.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс нийт давхардсан тоогоор 92 иргэнд цахим лавлагаа гаргаж үйлчилсэн байна. Үүнд:

- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт - 42
- Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн) - 42
- Иргэнд олгох тодорхойлолт – 2
- Төрсний бүртгэлийн лавлагаа - 1
- Иргэний үнэмлэхийн лавлагаа – 6 тус тус гарган ажилласан байна.

9 дүгээр сарын байдлаар суманд нийт 6 хүүхэд шинээр төрсний гэрчилгээ авч, 4 хүн нас барсан байна. 1 гэр бүл гэрлэлтээ батлуулж, 1 хүүхдийн үрчлэлт бүртгэгдсэн байна. Нийт иргэний үнэмлэх олгосон 13 бүртгэл хийгдсэн байна. Үүнээс 16 нас хүрч шинээр захиалсан 5 иргэн байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн мал эмнэлгийн газраас шинжилгээний баг ирж 537 толгой хонийг бруцеллез өвчнийг илрүүлэх шинжилгээнд хамруулсан ба 1 хонь эерэг гарч, 536 хонь толгой дараалан сөрөг урвалын дүнтэй гарсан. Мөн хорио цээрийн дэглэмд байх хугацаанд хил дамжин халдварлах шүлхий, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 537 толгой хонь бүрэн хамрагдсан.

Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, Мал угаалгын ажилд 4 ажлын хэсэг гарч 8 угаалгын ваннад ванндаж угаахаас гадна малчны хотонд шүршиж угааж, угаалгын ажлыг дуусгалаа. Сумын хэмжээнд бод 584, бог 139695, нийт 140279 толгой мал угаалганд хамрагдсан байна.

Дэлгэрхаан багийн нутаг Ганцтолгой гэдэг газар “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төслөөр гаргасан гүн өрмийн худгийг хүлээн авсан.

2020 оны сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийн дагуу 1-р багийн иргэн П.Мөнхтулгад 6,0 сая төгрөг, 3-р багийн иргэн Ч.Анхбаярт 40,0 сая төгрөгийн гэрээ байгуулан мөнгийг нь шилжүүлэн өгсөн.

Сумын нутаг дэвсгэрт газар тариалан эрхлэгчдийн хураан авсан ургац хураалтын мэдээг авч нэгтгэн газар тариалгийн нэгдсэн санд оруулаад байна. Нийт 2,7 тн төмс, 2,1 тн бусад хүнсний ногоо хураан аваад байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн даатгал, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: Хичээлийн 1-р байранд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 583 сая төгрөгөөр их засвар хийгдлээ. Их засварын ажлыг Улаанбаатар хотын “Ивээл Алдар” ХХК хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн бүх багш, ажилчдыг аймгийн ЭМТ-д урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрууллаа. Үүнд 62 хүн хамрагдав. Энэхүү үзлэг шинжилгээнд 3 насны ангилалаар 4 багцын шинжилгээг сонгон үзүүллээ.

Хичээлийн 1-р байранд их засвар хийсэнтэй холбоотой дунд, ахлах ангийг 1-р байранд хичээллүүлж бага анги хичээлийн II байранд хичээллэж эхэллээ. Үүнтэй холбоотой үдийн цайны заал хичээлийн II-р байранд байгуулж тохижууллаа. Шинээр 6,400,0 төгрөгний гал тогооны төхөөрөмжийг худалдан авлаа.

1-р ангид шинээр 78 хүүхэд элсэн суралцаж байгаа учир 6 настны бие засах газар модон ариун цэврийн байгууламжийг өөрсдийн хүчээр хийлээ.

1-9-р ангийн нийт 473 ширхэг сурах бичгийг татан авлаа.

6-9-р ангийн нийт суралцагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. 6-9-р ангийн нэгдсэн хурлыг хийж Хүүхдийн хүчирхийллийн эсрэг сургалт хийж, сургуулийн ХОБ-ын суралцагчыг сонголоо. Үүнд: Суралцагчдын зөвлөл 11 хүүхэд, Өсвөрийн цагдаа 7 хүүхэд, Эрүүл мэнд, ЭКО клуб 7 хүүхэд, Улаан загалмай 15 хүүхэд, Охидын клуб 9 хүүхэд Скаутын холбоо 55 хүүхэдтэйгээр тус тус үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: ЭМД-д 22 хүний 1313.7 төгрөг, СДД-д 7 хүний 414.7 төгрөг, НДШ-д төсөв болон ААН байгууллагын 27087,9 орлого орсон байна. 09 сарын тэтгэвэрт 2 банкаар 410 хүнд 144654,4 сая төгрөгний тэтгэвэр олгосон.

COVID-19 буюу цар тахалтай холбоотойгоор ЗГ-аас ААНэгжүүдийг НДШимтгэлээс чөлөөлөнө гэсний дагуу 16 ААНэгж сар бүр чөлөөлөлтөнд хамрагдаж байна.

Эрүүл мэндийн төв: “Эерэг хандлага, Эмчилгээ эхлэл” аяны хүрээнд Сүхбаатар аймгийн бүх сумдын эмч, сувилагч, жолооч нарын дунд ур чадварын тэмцээнд амжилттай оролцоод ирсэн.

Халзан:

Төрийн удирдлагын чиглэлээр: Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан болж 2020 оны орон нутгийн ээлжит сонгуулийн болохтой холбоотой 2-р баг сонгогчдын тоо 200 хүрэхгүй тул 3-р багтай нэгтгэн 3 хэсгийн хороо байсныг 4 хэсэг болгон нэмэх тогтоол шийдвэр гарсан.

Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгч БНХАУ-д 30000 хонь хандивлах шийдвэр гаргасантай холбогдуулан Халзан сум нийт 511 хонь цуглааж шинжилгээнд хамруулж ээмэгжүүлж, бүртгэжүүллээ.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ЕБС: Аймгийн ННС-аас зохион байгуулсан “Хязгааргүй эрх чөлөө” Номын баяр-2020 арга хэмжээнд сургуулийн номын санч оролцож, 2 өдрийн сургалтанд хамрагдсан. Энэ үеэр “Цахим өгүүллэг”-ийн богино уралдаанд 5а ангийн сурагч Б.Хас гутгаар байр эзэлсэн.

Цэцэрлэг: 110 хүүхдийн шинэ цэцэрлэг нээлтээ хийж, хүүхдүүдээ хүлээн авлаа. Яамны хөрөнгө оруулалтаар гал тогооны тоног төхөөрөмж, хүүхдийн ширээ сандал, хувцасны шкаф зэрэг 11.500.000₮-н эд зүйлс ирж хүүхдийн сурч хөгжих таатай орчин бүрдлээ.

Аймгийн 8-р цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцож, олон шинэлэг санааг ажилдаа тусган хэрэгжүүлж ажиллаж байна.

Соёл: Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Номын баяр арга хэмжээг сумандаа зохион байгуулж сургуулийн сурагчид болон насанд хүрэгчдийн дунд Богино өгүүллэгийн уралдаан зарлаж 5-р ангийн сурагч А.Хас, 7-р ангийн сурагч Давааням нар амжилттай оролцсоноос сурагч Хас аймгийн уралдаан оролцох эрх авч 3-р байранд орлоо. Мөн аймагт болсон Номын баярын үзэсгэлэн уралдаанд номын санч амжилттай оролцсон.

ЭМТ: Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдлаа. Шалгалтаар давхардсан тоогоор нийт 17 зөрчил илэрч, 8 зөрчлийг газар дээр нь арилган 29.3 хувийн бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Халзан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1-9 дүгээр ангийн нийт 189 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгууллаа. Нийт хүүхдийн 89 хувь нь амны хөндийн ямар нэгэн эмгэгтэй байсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: “Эрүүл хүнс- Эрүүл монгол хүн” уриан дор зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” улсын үзэсгэлэн худалдаанд Халзан сумын “Ариун хатавч” ХХК-ний үйлдвэрлэсэн хоол амтлагч /таанын сорс/“Орон нутгийн шилдэг хүнсний бүтээгдэхүүн” номинацид “Тэргүүн байр” эзэлсэн амжилт гаргалаа.

ЖДҮйлдвэр, Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр: Нийт 20 зээлдэгч байгаагаас 2020 оны 09сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 6 хүнээс 1,666,000мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Нийт 19 зээлдэгч нартай утсаар ярин эргэн төлөлтөнд төлөх тал дээр анхаарч ажиллаж байна.

“Covid-19” цар тахалтай холбогдуулан сумын хүнсний гол нэрийн нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг долоо хоногийн 3 дахь өдөр болгон аймгийн ХХААГазарт мэдээлж байна.

Мал эмнэлэг: Мал угаалгын ажил сумын хэмжээнд төвлөрсөн 3 цэгт явагдаж нийт 92186 бог, бод мал хамрагдаж угаалгын ажил дуусаад байна.

Байгаль орчны чиглэлээр: Сумын төвийн “Угталт үдэлтийн хаалганд төмөр торх шинээр байрлуулж орчны хог хаягдлыг цэвэрлэн архи, ундаа, авто машины дугуй зэрэг зүйлсийг ачиж нэгдсэн хогийн цэгт 2.3 тонн хогийг төвлөрүүлсэн.

Эрдэнэцагаан:

Удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн хүрээнд: Егүзэр хутагт Ж.Галсандашийн мэлмий гийсний 150 жилийн ойн арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу төр шашины хамтын удирдлаган дор сүсэгтэн олны дэмжлэг оролцоотойгоор ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

Төрийн албаны Улсын ёс зүйн зөвөлгөөнд төсвийн байгууллагуудыг онлайнаар оролцуулж, Сумандаа “ ИТГЭЛ ДААХ ТӨРИЙН АЛБАНЫ ТӨЛӨӨ” уриатай Төрийн албан хаагчийн ёс зүй сахилга хариуцлагыг сайжруулах зөвөлгөөн хийж байгууллагуудын дарга эрхлэгч нар болон холбогдох нэр бүхий 58 мэргэжилтэн албан хаагч хамруулж 2019 оны жилийн эцэс, 2020 оны хагас жилийн тайлангийн зөвлөмж чиглэлийг хүргэж ажиллалаа.

Төсөв,санхүү: Хугацаа хэтэрсэн зээлтэй 22 иргэнийн жагсаалтыг гаргаж 13 иргэнд мэдэгдэх хуудсыг өгч эргэн төлөлт 9-р сарын байдлаар 101050000 төгрөгийг төвлөрүүлэн ажиллаж, 8-н иргэнийг шүүхэд шилжүүлэх материалыг бүрдүүлсэн.

Боловсрол соёлын байгууллагын хүрээнд: Хүүхдийн 1-р цэцэрлэг: 2020-2021 оны хичээлийн шинэ жилд 308 хүүхэд хамрагдаж эхлээд байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүх албан хаагчдыг үзлэг шинжилгээнд хамрууллаа.

Ерөнхий боловсролын сургууль: 2020-2021 оны хичээлийн жилд удирдах ажилтан - 4, багш-61, ажилтан-29, бага ангийн 23 бүлэгт 718 сурагч, дунд ангийн 14 бүлэгт 459, ахлах ангийн 6 бүлэгт 197 сурагч буюу нийт 94 багш ажилтан, 44 бүлэгт 1374 сурагчтай хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.

Дарьгангын БЦГ-ын Хамгаалалтын захиргаанаас Орчны бүсийн сумд болох Дарьганга, Онгон, Наран, Асгат, Эрдэнэцагаан сумдын дунд “Шилдэг Эко клуб” шалгаруулах уралдаанд амжилттай оролцож 1-р байр эзэллээ.

Сургуулийн эмч анги удирдсан багш нартай хамтран 1-12-р ангийн сурагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 100% хамруулж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

Сургуулийн сурагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эцэг, эхчүүдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхээр “School police” хуваарийн дагуу ажиллаж эхэлсэн.

Соёлын төв: “Соёлын цаг өдөрлөг”-ийг бичигт боомт дахь “Төрийн банк” тооцооны төвтэй хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд хурдан уншигч, цэвэр сайхан бичигтэн шалгаруулах уралдааныг зарлан нийт 19 хүн оролцсон, мөн хөгжөөнт “ЧАНГА ШИВНЭЭ” тэмцээнийг зохион явуулж нийт 6 албаны 12 хүн амжилттай өрсөлдлөө.

Эх хэлээ эрхэмлэн дээдлэе цахим мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд татан байршуулсан. **Эх нутаг -Өв соёлоо эрхэмлэн дээдлэе”- аян** Халхын тамгат 13 хутагтын нэг Егүзэр хутагт Ж. Галсандашын 150 жилийн өндөр ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан өв соёлоо эрхэмлэн дээдлэн дэлгэрүүлэх сурталчилах зорилгоор Соёлын Биет Өв хадгалан хамгаалагчидтай уулзан нутгийн иргэдийн гар дээр байгаа түүх соёлын дурсгалт зүйл, эд өлгийн зүйлийг “Егүзэр хутагтын музей, хатиганы хар сүлдний өргөөнд 7 хоног байрлуулж” ирсэн зочид төлөөлөгчид ард иргэдэд сонирхууллаа.

Егүзэр хутагт судлаачид эрдэмтэн докторуудын хамт байгалийн үзэсгэлэнт газар ТСҮХДГ нутгийг танилцуулах маршрут гарган аялууллаа.

“НУТАГ МИНЬ, ХУТАГТ МИНЬ” хүндэтгэлийн тоглолтоо Эрдэнэцагаан сумаас төрөн гарсан яруу найрагчид, хөгжмийн зохиолчдын бүтээл туурвилаас сонгон оруулж нийт 50 иргэн буюу соёлын биет бус өв тээгчтэй хамтран ажиллаж ард иргэдэд толилууллаа.

ЗДТГ-тай хамтран зохион явуулсан “Угийн бичиг-Удмын бахархал” уралдааны дүнг гаргаж угийн бичгээ амжилттай хөтөлж дэлгэрүүлж яваа 3 иргэнийг Дурсамж дурсгалын зүйлийн хамтаар шагнаан урамшууллаа.

Эрүүл мэнд: ЭМТ-ийн “Хөтөч”-ийн үүрэгт ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Үүнд: амбулатороор үйлчлүүлэгчдийн халуун үзэж, гар ариутгаж, маск зүүхэд хяналт тавин маскгүй хүмүүст маск, гарын авлага тус тус тараан ажиллаж байна.

Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийг газар зэрэг баталгаат эх сурвалжаас авссан “Коронавирус (COVID-19) халдварын үеийн өдөр бүрийн өвчлөлийн мэдээлэл”, COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой болон бусад өвчлөлөөс урьдчилан сэргийлэх 74 төрлийн зөвлөмж, зөвлөгөөг цахим сүлжээгээр дамжуулан сум орон нутгийн болон албан байгууллагуудын цахим хуудсанд тавьж ажилласнаар хандалтын тоо -4052 болсон байна.

Жил бүрийн 09 сарын 17ны өдрийг “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах өдөр болгон тэмдэглэж ирсэнтэй холбогдуулан Коронавирусын цар тахлын эсрэг ажиллаж буй “Эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдлыг хангая” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүллээ.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээ: Ажилгүйдлийн бүртгэлд 55 иргэн шинээр бүртгэж, өмнө нь бүртгэлтэй байсан иргэдээс 20 иргэнийг сэргээж, шинээр 75 ажилгүй иргэдийг Limis-д бүртгэв.

Улсын бүртгэл: Төрсний бүртгэл 12 үүнээс эрэгтэй 7, эмэгтэй 5 Нас барсны бүртгэл 3 үүнээс эрэгтэй 1, эмэгтэй 2, Гэрлэсний бүртгэл 7, Гэрлэлт цуцалсны бүртгэл 2, Иргэний нэр, овог нэрийг өөрчилсний бүртгэх бүртгэл 1, Эцэг тогтоосны бүртгэлийн 4, Лавлагаа 10 иргэнд, Төрсний гэрчилгээний дахин олголтыг 3 хүүхдэд, Иргэний үнэмлэх сунгалт болон дахин олголтыг 26 хүний хурууны хээг авч 43 иргэнд захиалсан үнэмлэхийг олгож ажиллалаа.

Хөдөө аж ахуй: Ерөнхийлөгчийн БНХАУ-д хандивлахаар амласан 30 мянган хонийг цуглуулах ажлыг эхлүүлэн Гэр, хашаа барьж халдваргүйжүүлэлтийн цэг байгуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд 32000 толгой мал төллөсөн, том малын хорогдол 160 толгой мал үүнээс өвчнөөр 11 мал хорогдсон байна.

Өвс тэжээлийн нөөц бэлтгүүлэх ажлыг төлөвлөсөн ба энэ онд 150 тн өвс бэлтгэнэ. Одоогийн байдлаар 7 ААН өвс бэлтгэх гэрээ хийсэн байна. Сумаас 80 км газар хадлангуудыг гаргасан ба малчдын өөрсдийн бэлтгэсэн 250 тн өвс, 3 тн тэжээл бүртгэгдлээ.

Мал эмнэлгийн ажлын хүрээнд: Урьдчилан сэргийлэх вакцинд Цусан халдварт 17290 мал хамрагдахаас 16500 мал хамрагдаж 95%-тай, Боом-69203 мал хамрагдахаас 56750 мал хамрагдаж 82%, Галзуу-91335 – 85000 мал хамрагдаж 93%, Дотрын халдварт хордлого- 37983 100%, Дуут хавдар- 6325 мал хамрагдахаас 100%, Сахуу-3105 мал хамрагдахаас 100%, Шөвөг яр -10783 мал хамрагдахаас 100%

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд үхэр -26707 ямаа-140138, хонь-147725 нийт 314570 мал хамрагдаж 97%-н гүйцэтгэн дүн мэдээг нэгтгэн МЭГазарт хүргүүлсэн.

Бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх сумын засаг даргын А/136 тоот захирамж гарч , вакцинжуулалтанд 85500 охин төл хамрагдахаас 75800 охин төл хамрагдаж дүн мэдээг нэгтгэн авч байна.

Байгаль орчин: Сумын засаг даргын А/251 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд сумын төвийн эргэн тойронд байгаа 20 тн эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж ачуулсан. Егүзэр хутатын 150 жилийн ойн арга хэмжээний хүрээнд сумын төвийн 2.6 км засмал замыг цэвэрлүүлсэн.

Сумын засаг даргын захирамжаар аюулгүйн фонд буюу хадлангийн талбайд хяналт шалгалт хийсэн. Нийт 26 хадлангийн талбайд хяналт хийж ажлын явцтай танилцав.

Лхачинвандад уул болон Хэцүү жанжин ууланд байрлах буга, богоонд 4 тонн хужир шүү татаж тарааж өгсөн байна.

Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд: Иргэний үнэмлэхний лавлагаа 15, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн лавлагаа-2, гэрлэсний бүртгэлийн лавлагаа-4, жолоочийн лавлагаа-2, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагаа-62, иргэнд олгох тодорхойлолт-54, төрсний бүртгэлийн лавлагаа-5, шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт /Иргэн/-59, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхийн тодорхойлолт /Орон нутаг/-1 нийт 157 төрлийн лавлагаа, тодорхойлолт гаргаад байна. “

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар